

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 07 дугаар сарын мэдээ

2023.07.26

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын зөвлөлийг хуралдуулж сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдааныг зарлан хуралдуулах шийдвэр гаргалаа.

Сүхбаатар аймгийн” Эрдэнэ мандал хийд”-тэй хамтран сум орны сүсэгтэн олонд хур дуудах ном болон бусад номыг айлдлаа.

б/ **Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Тухайн сард дээд газраас 16 албан бичиг ирсний 5 нь хариутай, хугацаа болоогүй-2, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Сумын засаг даргын 06 дугаар сарын 29 өдрийн А/111 тоот захирамжаар сумын баяр наадмыг зохион байгуулах комисс томилогдон баяр наадмын үйл ажиллагааг 07 дугаар сарын 10,11 өдрүүдэд зохион байгууллаа.

Сумын баяр наадмаар Азрага-34, Их нас-60, Соёолон-47, Хязаалан-47, Шүдлэн-50, Даага-36 уралдсан байна. Хамгаалалтын хувцас хэрэглэлтэй, даатгалд хамрагдсан хүүхдүүд уралдааны замд гарсан бөгөөд уралдааны үеэр бэртэж гэмтсэн хүүхэд байхгүй болно. Хурдан морины уралдаанд хөрш зэргэлдээ Дорноговь аймгийн Өргөн, Дэлгэрэх, Замын үүд сумд, Халзан, Онгон, Мөнххаан зэрэг сумдаас морьд уралдсан.

Мөн сумын заан, сумын мэргэн цолтоны болзол хангасан 2 иргэнд цолны үнэмлэх мөнгөн шагналыг сумын засаг даргын захирамжаар олгосон.

Хоёр: **Төсөв санхүүгийн чиглэлээр:** 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 7 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн.

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгууллага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч нотиаротоор баталгааж, цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан, малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарын дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Төсвийн газруудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хугацаанд нь e-balance программд шивж сумын нэгдсэн тайлан гаргаж аймгийн санхүү төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж, аудитын газар хүргүүлж шалгуулсан.

Гүйлгээний баримтыг сар бүр архивлан үдсэн. Шилэн дансны мэдээлийг шивж оруулсан,

ОНХС-ын хийгдсэн ажлын төлөвлөгөө, ажлын хэсгийн жагсаалтыг программ-д шивж оруулсан.

Гурав. **Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Сумын баяр наадам болохтой холбогдуулан сумын Эрүүл мэндийн төвтэй хамтарч хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах, хоол хүнсээр дамжих хордлого халдвар, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж 11-н аж ахуй нэгж, 4-н зоогийн газар, 6 хуушуурын цэгт зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Соёл: Соёл урлагийн 10 үйл ажиллагаа болж 3840 хүн хамрагдлаа. Ардын хувьсгалын 102 жил, Сум үүсэн байгуулагдсаны 98 жилийн ойн баяр наадмын соёл урлагийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Монголын зохиолчдын эвлэлийн Сүхбаатар аймаг дах салбартай хамтран “Яруу увидас-7” яруу найргийн цэнгүүнийг зохион байгуулж МЗЭ-н Сүхбаатар салбарын гишүүн яруу найрагч Б.Аръяагийн уран бүтээлийн танилцуулга хүндэтгэлийн арга хэмжээ боллоо.

Сумын иргэдийн дунд “Зун цаг” цахим шүлгийн уралдаан зарлаж 14 шүлэг ирснээс 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шалгаруулж эхний 5 байрыг шалгаруулж, уралдаанд ирсэн шүлгүүдээр товхимол гаргаж бүх оролцогчдод дурсгав.

Монгол ахуй соёлоо эрхэмлэн дээдэлж хүүхэд залуучуудад өвлүүлэн үлдээх, үндэсний соёлоороо бахархах Монгол адууны соёлыг олон нийтэд суртчилан таниулах зорилгоор “Морьтон Монгол”, “Морин өртөө” тэмцээнүүдийг зохион байгууллаа. Уг тэмцээнүүдэд 6 багийн 21 хүн оролцож хүч чадал авхаалж самбаагаа сорьсноос тэмцээн тус бүрийн тэргүүн дэд байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Нутгийн залуу дуучин Э.Отгонцэцэгийн “Яруу эгшиглэн” тоглолтыг хамтран зохион байгуулсан.

Тулгар төрийн 2232, Их Монгол улсын 817, Ардын хувьсгалын 102 сум байгуулагдсаны 98 жилийн ойн баяр наадмын шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн тоглолт, нээлтийн үйл ажиллагаа, “Миний Монгол наадам” тоглолт, наадмын хаалтын үйл ажиллагаа, үдшийн цэнгүүн “Морин өртөө”, “Морьтон Монгол” тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Ногоон байгууламж болон өрхийн тарьсан модны ургалтын хувь 89 хувьтай байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, туслах ажил үйлчилгээнд нийтийг хамарсан ажилд ажиллах 4 иргэнтэй гэрээ байгуулан, хамтран ажиллаж байна.

Үндэсний их баяр наадмын өдрүүдээр 16 ширхэг хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг 4 цэгт байрлуулж, 6 иргэнтэй байгуулсан гэрээний дагуу наадмын талбай, талбайн орчмын хогийг түүж цэвэрлэн нийт 9 тн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүллээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагын тариалсан талбайн эцсийн мэдээг статистикийн цахим программд шивж оруулсан. Үүнд: 26 өрхийн 1,47 га талбайд төмс, 0,843 га талбайд хүнсний ногоо, 4 албан байгууллага 0,2 га –д төмс, 0,302 га-д хүнсний ногоо тариалсан. 2023 онд нийт 1,67 га талбайд төмс, 1,145 га талбайд хүнсний ногоо тариалснаас 0,214 га –д зуны хүлэмжийн тариалалт хийлээ.

Сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдөр ХХААХҮЯ-д хүргүүлж байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн